unesco

Together for PEACE

Silent Manga Catalogue

Teacher's Companion

サイレントマンガ

先生の手引き



Энх тайвны төлөө хамтдаа

"Дуугүй Манга" Багшийн Туслах Каталог

Published in 2022 by the United Nations Educational, Scientific and Cultural Organization, 7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France

and UNESCO Bangkok Office

© UNESCO 2022

This publication is available in Open Access under the Attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) license (https://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/). By using the content of this publication, the users accept to be bound by the terms of use of the UNESCO Open Access Repository (http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en). Open Access is not applicable to non-UNESCO copyright photos, illustrations and manga in this publication.

The designations employed and the presentation of material throughout this publication do not imply the expression of any opinion whatsoever on the part of UNESCO concerning the legal status of any country, territory, city or area or of its authorities, or concerning the delimitation of its frontiers or boundaries.

Editorial copyright COAMIX Inc. ©2011–2021, SILENT MANGA AUDITION® is a registered trademark of COAMIX Inc., in EU and related jurisdictions.

Illustrations: artists participating in SILENT MANGA AUDITION® Round 13

Project co-ordinator: Akané Nozaki
Writer: Santibhap Ussavasodhi
Production co-ordinator: Sirisak Chaiyasook
Copy-editor: Gregory Galligan
Localized into Mongolian by Global Lingo
Designer: Nattawud Nittayagun
Mascot designer (Penmaru): Roberto F.

TH/DOC/PIO/22/009-MN

2022 онд Франц улс, 75352 Парис 07 SP, Фонтеной 7 хаягт байрлах НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага,

ЮНЕСКО-гийн Бангкок дахь төлөөлөгчийн газраас хэвлэв.

© ЮНЕСКО 2022

Энэхүү зохиолыг Attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) зөвшөөрөлтэй (https://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/) Open Access буюу Нээлттэй хандалтаас унших боломжтой. Хэрэглэгчид тус зохиолын агуулгыг ашигласнаар ЮНЕСКО-гийн Нээлттэй хандалтын мэдээллийн санг ашиглах нөхцөлүүдийг (http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en) дагаж мөрдөхийг зөвшөөрч байна. Нээлттэй хандалт нь ЮНЕСКО-гийн бус зохиогчийн эрхийн зураг, чимэглэл, энэхүү хэвлэл дэх мангад хамаарахгүй.

Энэхүү зохиолд ашигласан тэмдэглэгээ, материалын танилцуулга нь аливаа улс, нутаг дэвсгэр, хот эсвэл бүс нутаг, түүний эрх баригчдын хууль ёсны статус, хил, заагийг нь тогтоохтой холбоотойгоор ЮНЕСКО байгууллага аливаа үзэл бодлыг илэрхийлсэн гэсэн утга агуулахгүй.

Редакцийн зохиогчийн эрх COAMIX Inc. ©2011–2021, SILENT MANGA AUDITION® бол "COAMIX" компанийн ЕХ, холбогдох улс орон дахь бүртгэлтэй худалдааны тэмдэг мөн.

Зураг: SILENT MANGA AUDITION® 13-р хэвлэлд оролцож буй уран бүтээлчид

Төслийн зохицуулагч: Акане Нозаки

Зохиолч: Сантибхап Уссавасодхи

Уран сайхны зохицуулагч: Сирисак Чайясук

Редактор: Грегори Галлиган (Англи хувилбар)

Глобал Лингоогоос Монгол хэл рүү хөрвүүлэв


Дизайнер: Наттавуд Ниттаягун (Англи-Тайланд хувилбар)

Бэлгэдэл амьтны дүрсний дизайнер (Пенмару): Роберто Ф.

About the front cover | Урд талын хавтасны тухай

The centre features an origami dove made of shapes in the 17 colours of the Sustainable Development Goals as the symbol of peace and how each goal comes together to build peace. Characters from the manga entries are included in each shape. Penmaru, the mascot of SILENT MANGA AUDITION® is at the bottom right corner of the cover.

Хавтасны төв хэсэгт буй Тогтвортой хөгжлийн зорилтуудын 17 өнгөт дүрсээр хийсэн оригами тагтаа нь энх тайвны бэлгэдэл бөгөөд зорилго бүр нь энх тайвныг бий болгохын тулд хэрхэн нэгдэж байдгийг харуулсан. Манга бичлэгийн дүрүүдийг хэлбэр бүрд оруулсан. SILENT MANGA AUDITION®-ийн бэлгэдэл Пенмаруг хавтасны баруун доод буланд дүрсэлсэн.



Together for Peace

Энх тайвны
төлөө хамтдаа:

Silent Manga Catalogue
Teacher's Companion

“Дуугүй Манга”
Багшийн
Туслах Каталог

Silent Manga refers to manga stories told entirely through illustrations without the use of dialogue. This Silent Manga Catalogue Teacher's Companion is intended for use by teachers (or parents) together with Silent Manga Catalogue, a compilation of Silent Manga entries selected from SILENT MANGA AUDITION® Round 13, which was based on the theme 'Together for Peace'.

The manga stories showcase different aspects of peace as envisioned by artists around the world, and based on various related topics such as out-of-school children, lifelong learning, anti-bullying, conflict, youth, learning to live together, refugees and shared histories. Through the power of Silent Manga, teachers can use such manga stories to spark a thought-provoking discussion among younger generations that represent the chief architects of world peace not only in our own times, but in the years to come.

Дуугүй Манга гэдэг нь харилцан яриа ашиглахгүйгээр бүхэлд нь зургаар илэрхийлсэн манга өгүүллэгүүдийг хэлдэг. Энэхүү "Дуугүй Манга" Багшийн Туслах Каталог "Энх тайвны төлөө хамтдаа" сэдэвт суурилсан SILENT MANGA AUDITION® Round 13 хэвлэлээс сонгож авсан Дуугүй Манга бүтээлүүдийн эмхтгэл болох "Дуугүй Манга" Багшийн Туслах Каталог нь багш нар (эцэг эхчүүд) хэрэглэхэд зориулагдсан болно.

Манга өгүүллэгүүд дэлхийн уран бүтээлчдийн энх тайвныг харах өөр, өөр өнцгийг илэрхийлдэг бөгөөд хүүхдийн сургууль завсардалт, насан туршийн боловсрол, бусдыг дээрэлхэхийн эсрэг, зөрчилдөөн, залуучууд, хамтдаа амьдрахад суралцах, дүрвэгсэд, хамтын амьдрал гэх мэт төрөл бүрийн холбогдох сэдэвт тулгуурладаг. Дуугүй Манга бүтээлийн ачаар багш нар энэ төрлийн манга өгүүллэгүүдийг ашиглан зөвхөн одоо цаг үед төдийгүй ирэх жилүүдэд дэлхийн энх тайвныг гардан бүтээгчдийн төлөөлөл болсон залуу үеийнхэнд нэгийг бодогдуулах хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой.

Silent Manga contain no dialogue and are meant to be read in Japanese style, right to left, which may be challenging for some readers. Summaries of manga stories are provided for easier comprehension. For further guidance, please refer to reading instructions on Page 4 of the Silent Manga Catalogue.

Reading comprehension questions (marked with 📖 icon) and **thought-provoking questions for group discussions** (marked with 💬 icon) are provided at the end of each manga summary.

📖 **Reading comprehension questions** can help assess if a student understands what he/she has read. They can be asked verbally or as a writing assignment after reading. There is no one correct answer to these questions. The questions are means to encourage students to express what they have understood and felt about the stories.

💬 **Group discussion** can encourage students to learn to express their viewpoints and to practise thoughtful reasoning. Students can be asked how they would address a certain issue if they were leaders or policymakers. Follow-up questions can be added by the teacher.

More activities are provided at the end of this Teacher's Companion. Teachers are welcome to adapt these activities as they see fit, including for online learning.

Дуугүй Манга нь харилцан яриагүй бөгөөд Япон хэв маягаар баруунаас зүүн тийш уншихад зориулагдсан бөгөөд энэ нь зарим уншигчдад хэцүү байж магадгүй юм. Ойлгоход хялбар болгох үүднээс манга өгүүллэгүүдийн хураангуйг оруулсан болно. Нэмэлт зааврыг Дуугүй Манга каталогийн 4-р хуудаснаас уншина уу.

Уншиж ойлгох асуултууд (📖 дүрсээр тэмдэглэсэн), бүлгийн хэлэлцүүлэгт зориулсан бодож тунгаах асуултуудыг (💬 манганы хураангуй бүрийн төгсгөлд оруулсан.

- 📖 Уншиж ойлгох асуултууд сурагч уншсан зүйлээ ойлгож байгаа эсэхийг үнэлэхэд тусална. Тэднийг уншсаных нь дараа асуултуудыг амаар эсвэл бичгийн даалгавар өгөх замаар асууж болно. Энэ асуултуудад зөв гэсэн нэг хариулт байхгүй. Асуултууд бол сурагчдад өгүүллэгүүдийн талаар ойлгож, мэдэрсэн зүйлээ илэрхийлэхэд нь туслах хэрэгсэл юм.

- 💬 Бүлгийн хэлэлцүүлэг нь сурагчдыг үзэл бодлоо илэрхийлж сурахад дэмжлэг үзүүлж, эргэцүүлэн бодох чадварт сургана. Сурагчдаас хэрэв тэд удирдагч эсвэл бодлого боловсруулагч байсан бол тодорхой асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг асууж болно. Багш дагалдах асуултуудыг нэмэх боломжтой.

Энэхүү Багшийн Туслах Каталогийн төгсгөлд илүү олон үйл ажиллагааг оруулсан. Багш нар онлайн сургалт оролцуулан эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах боломжтой.

Invisible | Үл үзэгдэгч



By João Eddie | Зохиолч Жоао Эдди


Brazil | Бразил

Standing in a landfill, a young boy, who has been forced by his stepfather to work by collecting rubbish, finds a book. During lunchtime, he throws his mouldy bread to the birds. At night, he sees in the book how children usually go to school. One day, the boy decides to run away. His stepfather tries to stop him, but is attacked by the birds. The boy breaks out crying, as he cannot catch up with the departing school bus. A woman whose image appears on the book's cover finds the boy with the book. In the end, the boy is introduced to a new life as the woman takes him to school.

Хойд эцгийнхээ албадлагаар хог түүх ажил хийж буй жаал хүү хогийн цэг дээр зогсож байгаад нэг ном олжээ. Тэр үдийн цайны цагаар хөгцөрсөн талхаа шувуудад өгдөг. Тэр шөнийн цагаар хүүхдүүд сургуульд ихэвчлэн хэрхэн сурдгийг номоос хардаг. Нэгэн өдөр хүү зугтахаар шийдэв. Хойд эцэг нь түүнийг зогсоохыг оролдсон ч шувууд түүн рүү дайрчээ. Хөдөлж буй сургуулийн автобусыг гүйцэж чадаагүй хүү уйлна. Номын нүүрэн дээр зураг нь байсан эмэгтэй хүүг номтой нь цуг олж харжээ. Эцэст нь эмэгтэй хүүг сургуульд хүргэж өгснөөр тэр шинэ амьдралтай танилцана.

Why does the boy collect books and stationery from rubbish?
Хүү яагаад хогоос ном, бичгийн хэрэгсэл цуглуулдаг вэ?

Why is the boy 'invisible'? Give examples of groups or people who are deemed 'invisible', and how they acquire such a label.
Хүү яагаад "үл үзэгдэгч" болсон бэ? "Үл үзэгдэгч" гэж тооцогддог бүлэг эсвэл хүмүүсийн жишээ гаргаж, тэд хэрхэн ингэж нэрлэгдэх болсон тухай жишээ тат.



In Your Shoes | Бусдыг өөртэйгөө адил мэдрэх

By Priscilla Miranda & Lucas Marques | Зохиолч Присцилла Миранда, Лукас Маркес

Brazil | Бразил

A teacher finds an old photo album while cleaning the bookshelf of her dilapidated school, and she cannot help recalling the difficult and emotional experiences of one of her students. The student is too poor to afford a book that he needs for his studies. With help from his caring teacher, he finally has a chance to study with the gift of a book she has presented to him. Years later, the boy, now an adult, returns to his alma mater with books that he donates for the benefit of current students.

Багш сургуулийнхаа хуучирсан номын тавиурыг цэвэрлэж байхдаа хуучин зургийн цомог олж, нэг сурагчийнхаа хэцүү, сэтгэл хөдөлгөм түүхийг эргэн санахгүй байж чадсангүй. Тэр оюутан дэндүү ядуу тул хичээлдээ хэрэгтэй номоо авч чадаагүй. Халамжит багшийнхаа тусламжтайгаар түүнд бэлэглэсэн номыг тэр эцэст нь авч сурах боломжтой болсон. Хэдэн жилийн дараа, одоо насанд хүрсэн хүү төгссөн сургуульд нь одоо сурч буй оюутнуудад номууд хандивлахаар буцаж ирдэг.

Why does the man donate books to his school?
Тэр залуу яагаад сургуульдаа номууд хандивласан бэ?

In addition to good books, what other things and ways are important for ensuring that children have access to education?
Хүүхдийг боловсрол эзэмшүүлэхэд сайн номоос гадна өөр ямар зүйл, арга зам чухал вэ?

Mr Roux's Math Class | Ноён Роусын тооны анги



By Akimichi | Зохиолч Акимичи


Russian Federation | Оросын Холбооны Улс

Students in school are enjoying their lessons in a mathematics class. An old janitor, disappointed with himself for not having had an opportunity to study when he was a young boy, looks on the happy students from the outside. The teacher then offers to clean the floor for the janitor, so that he might study, with further help provided by the students. The janitor, with his endless passion for learning, starts studying again until he one day completes his education.

Сургуулийн сурагчид математикийн ангид хичээлээ дурлан үзэж байна. Багадаа сургуульд сурах боломж олдоогүйдээ сэтгэл гонсойсон настай үйлчлэгч жаргалтай сурагчдыг гаднаас харж зогсоно. Тэгээд багш үйлчлэгчээс ангийн шалыг цэвэрлэхийг хүсдэг бөгөөд ингэснээр тэр сурагчдын тусламжтайгаар сурах боломжтой болно. Сурах хязгааргүй хүсэлтэй үйлчлэгч нэг л өдөр бүрэн сурах хүртлээ дахин суралцаж эхэлдэг.

What might be the factors that prevented the janitor from studying when he was a young boy?
Үйлчлэгч хүүхэд байхдаа ямар хүчин зүйлүүдээс болоод сурч чадаагүй байж болох вэ?

Give examples of things that you can share with an older generation, and things you will need to learn from a younger generation, in the future.
Ахмад үеийнхэнтэй хуваалцаж болох зүйлс, ирээдүйд залуу үеийнхнээс суралцах хэрэгтэй зүйлсийн жишээг хэл.



Chrysalis | Авгалдай

By Carriere Alexandre | Зохиолч Карьер Александр

France | Франц

A girl goes to school with a chrysalis in her insect feeding box. She hugs the box and avoids the crowd. A mental chrysalis has formed around her as she isolates herself. A boy approaches her and asks about the chrysalis, but she pushes him away. As the insect inside cracks the chrysalis open, the girl decides to open her mind, and she rushes to the boy and shows him a beautiful butterfly.

Нэг охин шавьж хооллох хайрцагт хийсэн авгалдайгаа аваад сургуульдаа явж байна. Тэр хайрцгийг тэврэн, олноос зайлсхийж байна. Тэр өөрийгөө олноос тусгаарлах үед түүний оюун санаа ч бас хайрцаглагдаж байв. Нэгэн хүү түүнд ойртож, авгалдайн тухай асуухад тэр түүнийг түлхэв. Авгалдай хагарах үед охины санаа бодол ч тэлж, хүү уруу гүйж очоод түүнд үзэсгэлэнтэй эрвээхийг үзүүлэв.

How does the girl make up with the boy? Why?
Охин хүүтэй хэрхэн эвлэрдэг вэ? Яагаад?

The 'wall' visible to the heart differs from one person to another. What can they be? Why do these walls exist?
Зүрх сэтгэлийн "хаалт" хүн бүрд өөр, өөр байдаг. Ямар хаалтууд байж болох вэ? Яагаад ийм хаалтууд байдаг вэ?

A Melody of Peace | Энх тайвны аялгуу



By Kenkyostudio | Зохиолч Кенкёстудио
Spain | Испани


A girl is bullied by her classmates, who have made fun of her for wearing a wig to hide her temporary baldness. After an accident, a classmate who had instigated the teasing visits a hospital. Inspired by his curiosity over the origin of a beautiful melody, he discovers his classmate playing her violin to cheer up other sick children with baldness caused by chemotherapy treatments for cancer. After witnessing that generosity of spirit, he repents for his former actions and convinces the rest of his classmates to shave their heads in collective apology.

Ангийнхан нь нэг охиныг дээрэлхэж, түр зуур халзан болсноо нуухын тулд хиймэл үс зүүсэн гэж шоолдог. Ослын дараа ангийнх нь хүү түүнийг өдөөн хатгахаар эмнэлэгт очжээ. Хүү сайхан аялгуу хаанаас гараад байгааг хайж очихдоо ангийнхаа охины хийл хөгжим тоглож, хорт хавдрын хими эмчилгээний улмаас халзан болсон бусад хүүхдүүдийг баярлуулж байгааг олж мэдэв. Тэр түүний өгөөмөр сэтгэлийг харсны дараа өмнөх үйлдлүүддээ гэмшиж, ангийнхаа бусад хүүхдүүдийг хамтдаа уучлалт гуйж, үсээ хусуулахыг ятгадаг.

Why does the boy feel remorse by his past actions in relation to the girl?
Хүү яагаад охинтой холбоотой өнгөрсөн үйлдэлдээ гэмшдэг вэ?

.....

What can be done to address bullying?
Дээрэлхэх байдлыг арилгахын тулд юу хийж болох вэ?



A Wordless Apology | Чимээгүй уучлалт гуйлт

By Marika Mangaka DZ | Зохиолч ДЗ Марика Мангака

Algeria | Алжир

A Syrian refugee who moves to a new school meets a boy who bullies her by making fun of her. The girl stops attending school for several days, and later he coincidentally finds her working for food. Out of curiosity, he follows her home and is shocked to find that she and her entire family have been going through tough times. Atoning for what he has done, he expresses his wordless apology by collecting donations with the help of his teacher and classmates, so they can buy everyday necessities for the girl and her family. The girl and the boy finally make up as friends.

Шинэ сургуульд шилжих ирсэн Сирийн дүрвэгч охин өөрийг нь дооглож дээрэлхдэг хүүтэй тааралдана. Охин хэд хоног хичээлдээ ирээгүй бөгөөд хүү дараа нь санамсаргүй байдлаар түүнийг хоолны мөнгөний төлөө ажил хийж байгааг харжээ. Тэр сониуч зандаа хөтлөгдөн охиныг гэр хүртэл нь дагадаг бөгөөд охин болон түүний бүх гэр бүл хүнд хэцүү үеийг туулж байгааг мэдээд цочирдов. Тэр буруугаа хүлээж, багш болон ангийнхаа хүүхдүүдийн тусламжтай хандив цуглуулж, охин болон түүний гэр бүлийнхний өдөр тутмын хэрэгцээт зүйлсийг авч өгөх боломжтой болсноор чимээгүй уучлалт гуйж байна. Эцэст нь охин, хүү хоёр найзууд болдог.


What are the possible hardships experienced by the girl and her refugee family?
Охин, түүний дүрвэгч гэр бүлд тохиолдож болох ямар бэрхшээл байгаа вэ?

.....

What can be the causes of bullying?
Дээрэлхэх ямар шалтгаанууд байж болох вэ?

The Lost Boy | Алдагдсан хүү

By gawinsat | Зохиолч Гавинсат
Thailand | Тайланд




Upon finding a book, a child soldier asks a prisoner being held by his militant group to teach him to read. One day, his fellow soldiers intend to kill the hostage, and a superior hands the child soldier a knife to execute the man. The boy imagines what a more normal life could be like if he could only pursue his education, and he drops the knife. When the militant superior is about to shoot the young soldier for his disobedience, another group of soldiers rescue the hostage and arrest the brutal militants. Both the hostage and the boy soldier survive the entire ordeal.

Цэрэг хүүхэд нэг ном олоод дайчдын бүлэгтээ хоригдож буй хоригдлоос уншихыг зааж өгөхийг хүснэ. Нэгэн өдөр түүний хамтрагч цэргүүд барьцаалагдсан хүнийг алахаар завдаж, ахлагч залуу хүүд хутга өгч, тэр хүнийг цаазал гэв. Хүү зөвхөн боловсрол эзэмшиж чадвал хэрхэн хэвийн сайхан амьдрал ямар болохыг төсөөлж, хутгаа буулгав. Цэргийн ахлагч залуу хүүг дуулгаваргүй байдлынх нь төлөө буудах гэж байхад өөр нэг хэсэг цэргүүд барьцаалагдсан хүнийг аварч, харгис хэрцгий дайчдыг баривчилжээ. Барьцаалагдсан хүн, цэрэг хөвгүүн хоёулаа бүх хүнд сорилтыг даван туулж чадсан.

Why does the boy decide not to execute the hostage as ordered by his superior?
Хүү яагаад барьцаалагдсан хүнийг ахлагчийнхаа тушаалаар цаазлахгүй гэж шийдсэн бэ?

How are child soldiers created? Why?
Цэрэг хүүхдүүд хэрхэн бий болдог вэ? Яагаад?



Tabletop Warfare | Ширээн дээрх дайн

By Joe Warat | Зохиолч Жо Варат
Thailand | Тайланд


A boy is witnessing two fights in progress in his own household kitchen. His parents are arguing because his father has broken an object; at the same time, two groups of ants are warring over a piece of biscuit. One of the ants sees what's going on and has an idea. It bites the boy and promptly hides from him. As the boy is looking for the ant, he falls off his chair. Only then do his parents stop arguing. As his mother tends to him, she sees her wedding photo. The parents make up, and the boy rewards the ants by splitting the biscuit between the two groups.

Нэг хүү гэрийнхээ гал тогоонд хоёр төрлийн тэмцэл болж байгааг харж байна. Аав нь эд зүйл эвдсэн тул эцэг эх нь маргалдаж байна, мөн үүний зэрэгцээ хоёр бүлэг шоргоолж хэсэг жигнэмгийн төлөө тэмцэлдэж байна. Шоргоолжнуудын нэг нь юу болж байгааг хараад нэг санаа олсон байна. Тэр хүүг хазаж, тэр даруйдаа түүнээс нуугдав. Хүү шоргоолжийг хайж байхдаа сандлаасаа унана. Тэгж байж л эцэг эх нь хэрэлдэхээ болино. Ээж нь түүнийг асарч байхдаа хуримынхаа зургийг хардаг. Эцэг эх нь эвлэрч, хүү нь жигнэмгийг хоёр бүлэгт хувааж, шоргоолжнуудыг шагнадаг.

How does the ant's bite help end the tabletop warfare?
Шоргоолжны хазсан нь ширээн дээрх дайныг зогсооход хэрхэн тусалдаг вэ?

Share your experience of trying to end an argument or a conflict of some kind. What did you do? Did it work?
Ямар нэгэн маргаан, зөрчилдөөнийг зогсоох гэж оролдсон туршлагаа хуваалц. Та юу хийсэн бэ? Амжилттай болсон уу?

Neither Bright Nor Dark | Гэгээтэй ч биш, харанхуй ч биш



By Laica Chrose | Зохиолч Лайка Хроуз


Brazil | Бразил

Two communities, the Sun people and the Moon people, are separated by a big wall. The Sun people believe that the Moon people are monsters that can summon dark clouds. Through a crack in the wall, a boy makes friends with someone from the 'monster' group. Angered by poor harvests caused by the dark clouds, the Sun people are about to fight the 'monsters'. The boy succeeds in stopping a developing conflict, working together with his 'friend', who turns out to be a young girl, not a 'monster'. The Sun people come to realise that the scary armour and dark clouds are for shielding the Moon people from the sun. Both Sun and Moon peoples then adjust their lifestyles so they can live together harmoniously.

Нарны хүмүүс ба Сарны хүмүүс гэсэн хоёр бүлэг том ханаар тусгаарлагдсан байдаг байжээ. Нарны хүмүүс Сарны хүмүүс хар үүлсийг дуудаж чаддаг мангасууд гэдэгт итгэдэг. Нэг хүү хананы ан цаваар "мангас" бүлгийн хэн нэгэнтэй найз болдог. Хар үүлнээс болж ургац муутай байгаад уурласан Нарны хүмүүс "мангасууд"-тай тулалдах гэж байна. Хүү "мангас" биш харин залуу охин болох "найз"-тайгаа хамтарч, өрнөж буй зөрчилдөөнийг амжилттай зогсоодог. Нарны хүмүүс аймшигт хамгаалалт, хар үүлнүүд Сарны хүмүүсийг нарнаас тусгаарлаж байсан гэдгийг ойлгодог. Тэгээд Нар, Сарны хүмүүс хамтдаа эв найртай амьдрахын тулд амьдралын хэв маягаа зохицуулдаг.

What do people of the two groups have to adjust to so they can live peacefully together?
Хоёр бүлгийн хүмүүс хамтдаа амар тайван амьдрахын тулд юуг зохицуулах ёстой вэ?

What is the relationship between diversity and empathy?
Олон талт байдал, өрөвдөх сэтгэл хоёр хоорондоо ямар хамааралтай вэ?



My Weird Roommate | Миний өрөөний хачин найз

By Heitor Amatsu | Зохиолч Хэйтор Амацу
Brazil | Бразил

A man and a woman with different lifestyles become roommates. The man loves loud music, while the woman loves meditating quietly with incense. One day, as the man is practising his guitar, the woman's meditation crystal breaks. Upon discovering this, she cuts the man's guitar strings in revenge. Then, as she goes out, the woman falls into a river. The man comes to her rescue, and he gives her a new crystal as an apology. When the man subsequently discovers his broken guitar strings, the woman gives him new strings as her apology. They make up and find themselves able to share the room in peace.

Өөр, өөр амьдралын хэв маягтай эрэгтэй, эмэгтэй хоёр хүн нэг өрөөнд хамт амьдрахаар болдог. Эрэгтэй нь чанга хөгжимд дуртай бол эмэгтэй нь хүж асааж, чимээгүй бясалгах дуртай. Нэг өдөр эрэгтэй гитараа тоглож байтал эмэгтэйн бясалгалын болор чулуу хагарна. Эмэгтэй үүнийг олж мэдээд тэр өшөө авахын тулд эрэгтэйн гитарын утсыг таслав. Тэгээд тэр эмэгтэй гарч явахдаа голд унажээ. Тэр залуу түүнийг аврахаар ирж, уучлалт гуйж, түүнд шинэ болор чулуу бэлэглэсэн. Дараа нь эрэгтэй гитарынхаа утас тасарсныг олж мэдэхэд эмэгтэй нь уучлалт гуйж, түүнд гитарын шинэ утас авч өгдөг. Тэд эвлэрч, өрөөгөө амар тайван хуваалцах боломжтой болсон.

What are the chief differences between the man and the woman?
Тус эрэгтэй болон эмэгтэй хүний гол ялгаанууд юу вэ?

How can people with differences in viewpoints or lifestyles live peacefully together?
Үзэл бодол, амьдралын хэв маяг нь ялгаатай хүмүүс хэрхэн хамтдаа амар тайван амьдрах боломжтой вэ?

Homeless | Тэнүүлч



By Simone Sanseverino | Зохиолч Симон Сансеверино


Italy | Итали

Separated from his usual group, a little penguin arrives alone at a tundra. He is discriminated against and is hurt by local birds led by a father bird. The local birds see the penguin as strange and 'different', because his wings are useless for flying. A blizzard blows away the father bird's egg, which is saved by the penguin, who is good at swimming. Not yet knowing this, the father bird finds the penguin and is about to attack him, when he is joined by his local followers. The bird couple is touched to learn that their egg is safe, and the father bird feels genuinely sorry for being so mean to the penguin.

Бяцхан оцон шувуу ижил сүргээсээ салж, ганцаараа тундрт ирдэг. Түүнийг эцэг шувуугаар удирдуулсан нутгийн шувууд гадуурхаж, гомдоодог. Нутгийн шувууд оцон шувууг хачирхалтай, "тэднээс өөр" гэж үздэг, учир нь түүний далавч нь нисэхэд хэрэггүй юм. Эцэг шувууны өндөг цасан шуурганд туугдаж, сэлэхдээ сайн оцон шувуу аварсан. Үүнийг хараахан мэдээгүй эцэг шувуу оцон шувууг олж, нутгийн дагалдагч шувуудтайгаа нийлэн түүн уруу дайрах гэж байсан. Хос шувуу өндөг нь аюулгүй гэдгийг мэдээд сэтгэл нь хөдөлж, эцэг шувуу нь оцон шувуунд муухай хандсандаа үнэхээр харамсдаг.

Why is the penguin not initially welcomed by the father bird and other local birds?
Яагаад оцон шувууг эцэг шувуу болон нутгийн бусад шувууд шууд хүлээн зөвшөөрөөгүй вэ?

How can differences breed hostility?
Ялгаатай байх нь хэрхэн дайсагнах байдал үүсгэдэг вэ?



Controversy of Sky | Тэнгэрийн маргаан

By Thuntopia | Зохиолч Тунтопиа
Thailand | Тайланд

After a World War, only arid desert remains on Earth, while adults are slumbering in the sky. A woman wakes up and sees a boy down below, earthbound, trying to find water from a sprout. She awakens other adults to help the boy, but they all end up fighting, as they are old enemies. As the boy is about to eat the sprout, he is stopped by an injured girl. At first they fight each other, too, but the boy suddenly stops, and they hug each other and cry together. Saddened by the incident, the adults join hands to create a stream, which enables plants to flourish again.

Дэлхийн дайны дараа газар дээр зөвхөн хуурай цөл л үлдэж, насанд хүрэгчид тэнгэрт унтдаг. Нэгэн эмэгтэй сэрээд доод талд нь нэг хүү газар луу тонгойж, соёолжоос ус хайж байхыг харав. Тэрээр хүүд туслахын тулд бусад насанд хүрэгчдийг сэрээдэг боловч тэд бүгд өмнө нь дайсагналцаж байсан тул хоорондоо зодолддог. Хүүг соёолж идэх гэж байтал нэг гэмтсэн охин түүнийг зогсоов. Эхэндээ тэд ч гэсэн хоорондоо зодолдсон ч хүү гэнэт зогсож, тэд бие биенээ тэврээд уйлдаг. Энэ үйл явдалд харамсаж буй насанд хүрэгчид ургамлуудыг дахин ургах боломжтой болгохын тулд гол горхийг сэргээдэг.

Why do the adults continue fighting after waking up in the sky?
Насанд хүрэгчид яагаад тэнгэрт сэрснийхээ дараа хоорондоо муудалцдаг вэ?

What can be the possible causes for spurring people to war with each other?
Хүмүүсийг хоорондоо дайтахад түлхэц болох ямар шалтгаан байж болох вэ?

Legacy | Өв залгамжлал



By YUKIRA | Зохиолч ЮКИРА

Malaysia | Малайз

An archaeologist excavating a site in Malacca finds a buried tomb. His consciousness suddenly travels back to the 15th century, as though he were a wealthy Chinese merchant. He then explores the history and diversity of the culture at the port city of Malacca. He kindly lends a hand to a boy of different race, who is in need of assistance. The boy then matures into a responsible person over the course of some years. The merchant passes away, and the archaeologist's consciousness returns to his own modern times. He realizes that he has experienced the life of the person who had saved the boy, who is one of his own ancestors.

Малакка дахь талбайд малтлага хийж байсан археологич оршуулсан булш олжээ. Түүний оюун санаа гэнэт 15-р зуун уруу буцаж, тэр чинээлэг Хятад худалдаачин байсан мэт санагдав. Дараа нь тэр Малакка хотын боомт дахь соёлын түүх, олон талт байдлыг судалжээ. Тэр тусламж хэрэгтэй байсан өөр үндэстний хүүд сайхан сэтгэлээр тусалдаг. Хүү хэдэн жилийн дараа хариуцлагатай хүн болж өсөж төлөвшдөг. Худалдаачин нас барж, археологичийн оюун санаа орчин цаг үедээ эргэж ирэв. Тэр өвөг дээдсийнх нь аль нэг тэр хүүг аварсан тухай амьдралыг мэдэрсэн гэдгээ ухаардаг.

How does the merchant treat the boy?
Худалдаачин тэр хүүд хэрхэн хандсан бэ?

What do people of South-East Asia have in common?
Зүүн өмнөд Азийн хүмүүс юугаараа адил төстэй вэ?



Over the Barriers | Бэрхшээлийг давсан нь

By AntiGA | Зохиолч АнтиГА
Italy | Итали


Four children are divided by manga frames. The first three are enjoying their time in their own frames, while by distinct contrast, a girl in the last frame apparently is living amid fighting. As the fighting intensifies, the boy who lives next to the girl's frame notices the situation. He then alerts the other two children. Working closely together, they remove parts of their manga frames to construct a ladder allowing the last girl to escape to safety.

Дөрвөн хүүхэд манганы жаазанд хуваагддаг. Эхний гурван хүүхэд нь өөрсдийн жаазанд тоглож, цагийг зугаатай өнгөрүүлж байгаа бол эсрэгээрээ сүүлийн жаазны охин тэмцэл дунд амьдарч байгаа бололтой. Тэмцэл ширүүсэх тусам охины жаазны хажууд амьдардаг хүү нөхцөл байдлыг анзаарчээ. Тэгээд тэр хүү нөгөө хоёр хүүхдэдээ анхааруулдаг. Тэд нягт хамтран ажиллаж, манганы жаазныхаа хэсгүүдийг салгаж, охиныг аюулгүй газар уруу зугтах шат барьж өгдөг.

How do the three children help the girl in the troublesome manga frame?
Гурван хүүхэд манганы жаазанд хэцүү байдалд байсан охинд хэрхэн тусалдаг вэ?

What can the frames and the ladder in this manga be compared with in reality? Why?
Энэ манганы жааз, шатыг бодит байдал дээр юутай харьцуулж болох вэ? Яагаад?

Prototype | Анхны загвар



By Bakti Abdul Jabar & Jabbar Wardana | Зохиолч Бакти Абдул Жабар, Жаббар Вардана

Indonesia | Индонез

In an industrial factory, robots are being produced for fighting purposes. An accident has caused one of the robots to fall from the production line, its head hitting the floor, activating the installation of the original software, which is peace-loving. The robot wakes up and is confused to see other robots being produced for fighting. It then has the idea to transfer the original software to its fellow robots via a main server. Successfully escaping surveillance, the robot manages to install the original software to the server, and the data is thereby copied to all the remaining robots.

Аж үйлдвэрт байлдааны зориулалттай робот үйлдвэрлэдэг. Ослын улмаас роботуудын нэг нь үйлдвэрлэлийн шугамаас унаж, толгойгоо шаланд цохиж, энх тайвныг эрхэмлэдэг анхны программ хангамж нь идэвхэжсэн. Робот сэрж, бусад роботуудыг байлдааны зориулалтаар үйлдвэрлэж байгааг хараад эргэлзэв. Тэгээд түүнд үндсэн программ хангамжаа үндсэн серверээр дамжуулан бусад роботууд уруугаа шилжүүлэх санаа төрсөн. Хяналт шалгалтаас амжилттай мултарч, робот анхны программ хангамжийг серверт суулгаж чадсан бөгөөд ингэснээр өгөгдлийг үлдсэн бүх робот уруу хуулж чаддаг.

Why does the robot want to install the original software to the other robots? What does the peace-loving robot do to achieve this?
Робот яагаад бусад роботуудад анхны программ хангамжийг суулгахыг хүсдэг вэ? Энхийг эрхэмлэдэг робот үүний тулд юу хийдэг вэ?

What are opportunities and challenges caused by artificial intelligence (AI)?
Хиймэл оюун ухаан (ХОУ)-аас үүдэлтэй ямар боломж, сорилтууд байдаг вэ?

Some of these writing tasks can be assigned for students to practice their creative writing skills. Appropriate word limits can be added.

1. **Dialogue writing:** Write dialogues that characters in the manga frames might say if this were not a Silent Manga.

2. **Summary writing:** Write a summary of a Silent Manga and what one has learned from it.

3. **Novelization:** Write a short story based on a chosen Silent Manga.

4. **Turning point analysis:** Identify a possible turning point in a manga, and explain why it is important to the storyline.

5. **Character analysis:** Write a review of a manga character and how and why it changes in personality or behaviour over the course of the story. Refer to the Characters Sheet on Page 27, if needed.



Эдгээр бичих даалгаврын заримыг сурагчдад бүтээлч бичих чадвараа сайжруулахад зориулж өгч болно. Тохиромжтой үгийн хязгаарыг нэмж болно.

1. **Харилцан яриа бичих:** Хэрэв энэ нь дуугүй манга биш байсан бол манганы баатруудын хэлж болох харилцан яриаг бич.

2. **Дүгнэлт бичих:** Дуугүй манга болон түүнээс юу сурснаа хураангуйлан бич.

3. **Зохиол бичих:** Сонгосон Дуугүй мангандаа үндэслэн богино өгүүллэг бич.

4. **Эргэлтийн цэгийн шинжилгээ:** Манга дахь эргэлтийн цэгийг тодорхойлж, яагаад энэ нь тус үйл явдалд чухал болохыг тайлбарла.

5. **Дүрийн шинжилгээ:** Нэг Манга дүрийг сонгож, өгүүллэгийн явцад түүний зан чанар, харьцаа хэрхэн, яагаад өөрчлөгддөг талаар тойм бич. Шаардлагатай бол 27 хуудаснаас дүрүүдийн тухай үзнэ үү.



Activity 1: Role-playing (with or without dialogue)

1. Divide students into groups.
2. Draw lots to decide which manga a group will do the role-playing, and their order of performance.
3. The numbers of characters in a manga and group members may vary. The story can be adapted to the particular circumstances at hand.

Activity 2: Mime

1. Divide students into two groups.
2. Each group takes turn in sending a member to the teacher, who will point to one character from the Characters Sheet on Page 27.
3. The student performs the mime based on the chosen character, while others try to guess from which manga the mime originates, as well as which particular character the student is miming.
4. The group that can answer correctly scores a point. The group with the highest points after several rounds wins the game.

Activity 3: Drawing manga

Ask students to draw their favourite manga character(s) from the Silent Manga Catalogue or from a manga they read. Also ask them to share why they love this/these characters.

Older students can be asked to draw a three-panel or a four-panel manga strips. To add another layer of challenge, the manga strips can be silent manga. (Only onomatopoeia is allowed.)

1-р үйл ажиллагаа 1: Жүжигчилсэн тоглолт (харилцан яриатай эсвэл дуугүй)

1. Сурагчдыг бүлгүүдэд хуваа.
2. Аль манга бүлэг жүжиглэсэн тоглолт хийх, тоглох дарааллыг сонгохын тулд сугалаа сугалуул.
3. Манга болон бүлгийн гишүүдийн дүрүүдийн тоо өөр байж болно. Өгүүллэгийг тухайн нөхцөл байдалд тохируулан өөрчилж болно.

2-р үйл ажиллагаа: Нүүрийн хөдөлгөөнөөр дүрслэх

1. Сурагчдыг хоёр бүлэгт хуваа.
2. Бүлэг бүр 27-р хуудасны дүрүүдийн нэгийг зааж харуулах багш уруу ээлжлэн нэг гишүүн илгээнэ.
3. Оюутан сонгосон дүрийг нүүрийн хөдөлгөөнөөр илэрхийлэх бөгөөд бусад нь тухайн сурагч аль манганаас гаралтай, ямар дүрийг дуурайж байгааг таахыг хичээнэ.
4. Зөв хариулж чадсан баг оноо авна. Хэд хэдэн үеийн дараа хамгийн өндөр оноо авсан бүлэг тоглоомд хожно.

3-р үйл ажиллагаа: Манга зурах

Суралцагчдаас Дуугүй манга каталогоос эсвэл манганаас уншсан өөрийн дуртай манга баатруудыг зурахыг хүс. Мөн тэднээс яагаад энэ/эдгээр дүрд дуртай байгаагаа илэрхийлэхийг хүс.

Арай том насны сурагчдаас гурван хэсэг эсвэл дөрвөн хэсэг бүхий манга цуврал зурахыг хүсэж болно. Өөр нэг сорилт нэмэхийн тулд манга цуврал нь дуугүй манга байж болно. (Зөвхөн гаргадаг дуу авиаг нь оруулахыг зөвшөөрч болно.)

Do let us know how you use the Silent Manga Catalogue for teaching and learning! You can do so by way of the following:

1) Share your story and photos with us by email, at pio.bangkok@unesco.org.
2) Post several photos on social media with captions. Please add #TogetherForPeace and #SilentMangaAudition and tag these social media accounts depending on the platform you use.

@unescobangkok and @SilentMangaAudition

@unescobangkok and @SilentMangaComm

@unescobangkok and @silent_manga_audition

By submitting photos to us or by posting photos on social media, please make sure that you have obtained permission from any persons, adults and parents/guardians of children, who are featured in the photograph(s).

Дуугүй манга каталогийг заах, сурахад хэрхэн ашигладаг талаар бидэнд мэдэгдээрэй! Та дараах байдлаар мэдэгдэх боломжтой.

1. Өөрийн түүх, зургаа pio.bangkok@unesco.orgхаягаар бидэнтэй хуваалцаарай.
2. Олон нийтийн сүлжээнд хэд хэдэн зургийг тайлбартай нийтэл. #TogetherFor Peace болон #SilentMangaAudition-г нэмж, тус хаштагуудыг ашиглаж буй платформоосоо хамааран олон нийтийн сүлжээнд оруулна уу.


@unescobangkok, @SilentMangaAudition

@unescobangkok, @SilentMangaComm

@unescobangkok, @silent_manga_audition

Бидэнд зураг илгээх эсвэл олон нийтийн сүлжээнд зургаа нийтлэхдээ тухайн зураг(ууд) дээр байгаа аливаа хүн, насанд хүрэгчид, хүүхдийн эцэг эх/асран хамгаалагчаас зөвшөөрөл авсан эсэхээ шалгана уу.

Characters Sheet Page | Манга дүрүүдийн жагсаалтын хуудас



Хамтран ажилласан байгууллагууддаа
онцгойлон талархал илэрхийлье.

From
the People of Japan

SMA! SILENT MANGA AUDITION

JAPANFOUNDATION

หอศิลปวัฒนธรรมแห่งกรุงเทพมหานคร
BANGKOK ART AND CULTURE CENTRE

กรุงเทพมหานคร

KP Learning Space

UNESCO Bangkok Office
Mom Luang Pin Malakul Centenary Building

920 Sukhumvit Road, Prakanong,
Klongtoei, Bangkok 10110, Thailand

bangkok@unesco.org
+66 2 391 0577

https://bangkok.unesco.org
@unescobangkok